



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
АЛБАНД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,  
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.05.14 № 01/838

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тендерийн баримт бичиг  
хянасан тухай

Танай албанаас зарласан “Сонгуулийн сурталчилгааны нэгдсэн самбар” ЧДХААА/20240101142 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг “Алтан зуун” ХХК-аас ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 19.3-т “Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”, Барилга хот байгуулалтын яамнаас олгодог: БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт тохижилтын ажлын тусгай зөвшөөрөлтэй байна...” гэж заасан байна.

Тус ажил нь Барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 211 дүгээр тушаалаар батлагдсан “Барилга, байгууламжийн түвэгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журам” нэгдүгээр хавсралт хүснэгтийн 22-т заасны дагуу “түр байгууламж” нь “барилгын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж”-д хамаарахаар байх тул захиалагч тус тендерийн баримт бичигт ажил гүйцэтгэхэд шаардлагагүй тусгай зөвшөөрлийг шаардсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2-т “Зөрчлийг арилган, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэхийг даалгах” гэж заасны дагуу тендерийн баримт бичигт холбогдох өөрчлөлтийг оруулж, хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу.

ДАРГА



Б.БИЛГҮҮН

0001709